



“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

**2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар
болгосон аудитын тайлан**

Улаанбаатар хот

2026 он



"ХАЙ БИ ОЙЛ" ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг
Утас: 976-7013-1770
Гар утас: 9511-1770

Аудитор: Ц.Алтанцэцэг
Гар утас: 95111770

Чанарын хяналтын аудитор
Б.Сансармаа
Гар утас: 91005906

Аудиторын туслах Э.Мөнгөннавч

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
Компьютер молл 9009 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

Вэб хуудас: www.pma.mn

АГУУЛГА

ХУУДАС

Хараат бус аудиторын тайлан	2-4
Санхүүгийн байдлын тайлан	5
Орлогын тайлан	6
Мөнгөн гүйлгээний тайлан	7
Өмчийн өөрчлөлтийн тайлан	8
Санхүүгийн тайлангийн тодруулга, компанийн товч мэдээлэл, танилцуулга	9-11
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй	12-18
Санхүүгийн тайлангийн тодруулга	19-25

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо:

№

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ХАЙ БИ ОЙЛ" ХК-ийн удирдлагад

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид "Хай Би Ойл" ХК (Компани гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-25 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа, тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах, компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг.

Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Хай Би Ойл" ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


"Пантер Мидланд Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"ХАЙ БИ ОЙЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	351,103,314.74	606,035,311.72
Дансны авлага	108,200,650.00	67,653,650.00
Татвар, НДШ-ийн авлага	2,523,761.91	27,269,747.61
Бусад авлага	354,283,000.01	406,498,936.48
Бараа материал	8,013,148.54	6,815,882.14
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,453,979.75	8,365,969.28
Эргэлтийн хөрөнгийн дүн	825,577,854.95	1,122,639,497.23
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,239,419,233.17	1,464,042,385.42
Биет бус хөрөнгө	869,916,700.00	869,916,700.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,282,879,519.00	2,282,879,519.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,392,215,452.17	4,616,838,604.42
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,217,793,307.12	5,739,478,101.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	68,409,200.00	71,136,200.00
Цалингийн өглөг	24,000.06	34,999.99
Татварын өр	49,922,813.99	62,073,338.45
Бусад богино хугацаат өр төлбөр	84,723,226.00	1,200,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	203,079,240.05	134,444,538.44
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	0.00	0.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
Өр төлбөрийн нийт дүн	203,079,240.05	134,444,538.44
Эздийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	5,211,895,400.00	5,211,895,400.00
Халаасны хувьцаа	(54,281,480.00)	(54,281,480.00)
Нэмж төлөгдсөн капитал	4,592,503,138.14	4,592,503,138.14
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,108,461,115.93	1,108,461,115.93
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(5,843,864,107.00)	(5,253,544,610.86)
Эздийн өмчийн дүн	5,014,714,067.07	5,605,033,563.21
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,217,793,307.12	5,739,478,101.65

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"ХАЙ БИ ОЙЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
Борлуулалтын орлого (цэвэр)	1,392,742,309.39	1,512,393,381.77
Борлуулалтын өртөг	558,857,540.65	553,134,423.54
Нийт ашиг (алдагдал)	833,884,768.74	959,258,958.23
Хүүний орлого	4,109,139.35	8,220,567.51
Ногдол ашгийн орлого	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	15,276,688.14	160.03
Ерөнхий ба удирдлагын зардал	257,232,540.65	302,568,371.99
Санхүүгийн зардал	0.00	0.00
Бусад зардал	14,840,114.83	5,776,130.84
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(205,233.44)	(2,688,191.78)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	580,992,707.31	656,446,991.16
Орлогын татварын зардал	59,603,805.55	66,491,131.37
Татварын дараах ашиг (алдагдал)	521,388,901.76	589,955,859.79
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	521,388,901.76	589,955,859.79
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	521,388,901.76	589,955,859.79

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"ХАЙ БИ ОЙЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	(6,365,928,315.75)	4,492,648,858.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	676,306.99	676,306.99
Запруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	(6,365,253,008.76)	4,493,325,165.31
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	521,388,901.76	521,388,901.76
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	(5,843,864,107.00)	5,014,714,067.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	363,836.35	363,836.35
Запруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	(5,843,500,470.65)	5,015,077,703.42
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	589,955,859.79	589,955,859.79
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	(5,263,544,810.86)	5,605,033,563.21

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"ХАЙ БИ ОЙЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	1,409,540,696.65	1,704,179,720.00
Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого	1,409,540,696.65	1,704,179,720.00
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	1,018,255,316.48	875,785,925.63
Ажилчдад төлсөн	195,134,395.72	234,140,279.05
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	60,837,282.57	67,375,947.23
Бараа материал худалдан авахад төлсөн	380,308,520.46	220,672,452.60
Ашиглалтын зардалд төлсөн	26,608,955.02	0.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	134,148,709.05	84,499,550.05
Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
Татварын байгууллагад төлсөн	169,066,384.29	217,409,877.30
Даатгалын төлбөрт төлсөн	1,073,645.00	224,532.00
Бусад мөнгөн зарлага	51,077,424.37	51,463,287.40
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	391,285,380.17	828,393,794.37
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	151,966,221.09	217,345,360.46
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Бусдад олгосрон эзэл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	148,127,584.99	209,348,023.35
Хүлээн авсан хүүний орлого	3,838,636.10	7,997,337.11
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	464,435,454.55	771,192,602.42
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	249,435,454.55	172,082,227.27
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Бусдад олгосон эзэл, мөнгөн урьдчилгаа	215,000,000.00	599,110,375.15
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(312,469,233.46)	(553,847,241.96)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	757.96	42,013.98
Эзэл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн ашиг	757.96	42,013.98
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	36,756,003.00	19,656,569.41
Эзэл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	36,756,003.00	19,653,363.64
Ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	3,205.77
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(36,755,245.04)	(19,614,555.43)
Ханшийн тэгшитгэлийн алдагдал	(10,591.41)	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,050,310.26	254,931,996.98
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	309,053,004.48	351,103,314.74
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	351,103,314.74	606,035,311.72

НЭГ. "ХАЙ БИ ОЙЛ" ХК-ИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Эдгээр тэмдэглэлүүд нь өмнөх санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.

" ХАЙ БИ ОЙЛ" ХК-ИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- *Байршил:* Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, 18135 товчооны зам гудамж, 59 тоот өөрийн байранд Утас1: 976-11-70112205, 99098989
- *Өмчийн хэлбэр:* Хувьцаат Компани
- *Харилцдаг санхүү, татварын байгууллага:* Сонгинохайрхан дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
- *Тайлангийн хугацаа:* 2025 оны 01 сарын 01-нээс 2025 оны 12 сарын 31
- *Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*
 - ✓ Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - ✓ Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах
- *Аудитор:* "Эвиденсе аудит" ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Хоймор офисс 502 тоот Утас:

" ХАЙ БИ ОЙЛ" ХК-НИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Хай би ойл" ХК нь 2007 оны 12 дугаар сарын 27-нд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 9010001063 тоо улсын бүртгэлийн дугаартай, 2615134 тоот регистрийн дугаартай гэрчилгээг аван дараах үйл ажиллагааг эрхлэн явуулах болсон байна.

Үүнд:

- ✓ Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах

"Хай Би Ойл" ХК нь шатахуун, тос тосолгооны материалын бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд 2008 оноос уул уурхай, газар тариалан, авто тээврийн салбар, засвар үйлчилгээний газруудаас хаягдаж буй аюултай хог хаягдал болох техникийн хаягдал тосыг дахин боловсруулж бүтээгдэхүүн болгох үйлдвэрийг ажиллуулж байна.

"Хай Би Ойл" ХК нь Монгол улсын хэмжээнд БОАЖЯ-ны "Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгадах, дахин боловсруулах, устгах" үйл ажиллагаа эрхлэх 0000009 тоот бүргэлийн дугаартай тусгай зөвшөөрөлтэйгээр техникийн хаягдал тосыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг явуулж байгаа.

Тус үйлдвэрийн технологи Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VMAT I-36 системийн техникийн хаягдал тос дахин боловсруулах бүрэн автомат тоног төхөөрөмж дээр суурилан явагддаг. Хонг Конгийн Данвелль компани нь 1990 оноос эхлэн техникийн хаягдал тосыг дахин боловсруулах аргыг туршин үйлдвэрлэлд нэвтрүүлэн өнөөдрийг хүртэл амжилттай хөгжүүлж ирсэн байна.

Үйлдвэрийн хүчин чадал жилд 1400 тн ажилласан тос боловсруулах хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар зах зээлийн үнэ, түүхий эд бүтээгдэхүүнийн чанараас хамааран зөвхөн галалгааны түлшний зориулалтын M-100 маркийн мазутыг үйлдвэрлэж байна.

"Хай Би Ойл" ХК нь 2008 оноос хойш Хонг Конгийн Данвелль компанийн үйлдвэрлэсэн VMAT I-36 системийн техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийг ажиллуулан өөрийн орны уул уурхай болон бусад салбарын техник, тоног төхөөрөмжөөс гарч хаягдаж буй ажилласан маслыг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Энэхүү боловсруулах үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед жилд 2400тн техникийн хаягдал тос дахин боловсруулах хүчин чадалтай юм. Үйлдвэрийн үйл ажиллагаа дулаан улиралд буюу 4-10 дугаар саруудад нийт 7 сар ажиллана. Энэ үед жилд 1400 тн техникийн ашигласан тосыг боловсруулна.

Үйлдвэр нь ажилласан тосыг центрифуг, нарийн шүүлтүүр, ууршуулагч болон VSEP мембранан шүүлтүүрийн аргаар цэвэрлэдэг автомат удирдлагын системтэй орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд дараах зарчмаар ажиллана.

Түүхий эд (техникийн хаягдал тос)-ыг үйлдвэр доторхи 25 м³-ийн савнаас насосоор шахаж 10м³ багтаамжтай тунгаагуур саванд өгнө. Тунгаагуурт ажилласан тосны найрлаганд байх ус, элс, том хэмжээтэй хатуу хольцуудыг тунгаан механик цэвэрлэгээ хийж, найрлагыг нь жигдрүүлэх процесс явагдана.

Тунгаагуурын дээд хэсгээс хаягдал тос 2.0м³-ийн багтаамжтай завсрын саванд өөрийн урсгалаар юүлэгдэн орно. Хаягдал ажилласан тосыг завсрын савнаас насосоор соруулан авч центрифугт шахах ба энд төвөөс зугатах хүчний үйлчлэлээр суспенз болон дунд зэргийн хэмжээ, масстай механик хольц нь цэвэрлэгдэнэ.

Центрифугээр дамжин 2 дахь цэвэрлэгээ хийгдсэн тос нь дулаан солилцуулагч болон нэрэгчинд тодорхой даралттайгаар өгөгдөнө. Энд хаягдал ажилласан тосны температурыг дээд тал нь 100°C хүртэл нэмэгдүүлж түүний найрлагад байгаа ус, чийгийг ууршуулан конденсацид оруулах процесс явагдана.

Дулаан солилцуулагчаар дамжин халсан тос нь дахин 20 меш буюу 0.8мм хэмжээтэй шүүлтүүрээр шүүгдэн эндээс 3.0м диаметртай 20м³ багтаамж бүхий конус хэлбэрийн ёроолтой дамжуулах сав гэж нэрлэгдэх тэжээлийн саванд өгөгдөнө. Техникийн хаягдал тосыг халаах үед өндөр температурын үйлчлэлээр хэсэг хугацааны дараа түүнээс ус чийг нь ууршина. Техникийн хаягдал тосыг механик хольцууд болон уснаас салгаснаар өтгөрсөн тос буюу мазутыг үйлдвэрлэдэг байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн тогтоолоор ТУЗ-ын гишүүдийн баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн тогтоолоор ТУЗ-ийн даргаар Б.Дөлгөөнтамирийг дахин томилсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөл:

Б.Дөлгөөнтамир	ТУЗ-ийн дарга
У.Энхбилэг	ТУЗ-ийн гишүүн
Б.Батбаатар	ТУЗ-ийн гишүүн
С.Одгэрэл	ТУЗ-ийн гишүүн
Р.Оюунбат	ТУЗ-ийн гишүүн
Ш.Амар-отгон	ТУЗ-ийн гишүүн
Б.Гэрэлтуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Т.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Г.Бадамдорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гүйцэтгэх удирдлага:

Ш.Амар-отгон	"Хай Би ойл" ХК-ийн гүйцэтгэх захирал
--------------	---------------------------------------

Ш.Амар-отгоныг 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн эхлэн компанийн гүйцэтгэх захирлаар томилон ажиллуулж байгаа.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс авсан мэдээллийн дагуу тус компаний нийт хувьцаа эзэмшигч нь 405 буюу 52,118,954 ширхэг хувьцаатай байна.

Том хувьцаа эзэмшигчид:

Хувьцаа эзэмшигчийн нэр	тоо ширхэг	хувь
Төгөлдөр мегаминкс ХХК	8,256,727.00	15.84
Кибер циркл ХХК	16,609,841.00	31.87
Монгол Алтан минт ХХЗ	4,167,934.00	8.00
Нью альфа ХХК	17,327,908.00	33.25
Жижиг хувьцаа эмэшигчид	5,756,544.00	11.05
нийт хувьцаа	52,118,954.00	100.00

/Энэхүү мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалаас үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2025 оны 04 сарын 08-ний өдөр авсан мэдээлээс авсан болно./

Аудитлагдсан санхүүгийн тайлан нь зөвхөн "Хай Би Ойл" ХК-ийнх бөгөөд тоон мэдээллүүд нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг /MNT/-өөр илэрхийлэгдсэн байна.

ХОЁР. “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Тус компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримтална.

Даган мөрдөх тайлан

Санхүүгийн тайлангууд нь НББОУС-ын Хорооноос гаргаж мөрдүүлсэн СТОУС болон НББОУХ-ны тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг даган мөрдөнө.

Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайланг бэлтгэх зорилго нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв илэрхийлэх явдал юм.

Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харах) бусад зүйлсийн хувьд өртөгт түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хэрэглүүр - Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр
- Санхүүгийн хэрэглүүр - Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн хэрэглүүр - Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн өр төлбөр - Санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр

НББ-ийн ерөнхий суурь

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

Тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн. Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй

байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг элэгдүүлдэг хөрөнгөнүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйн татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэний хэмжилт

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээлийн мэдээлэл дээр үндэслэгдээгүй тохиолдолд тэдгээрийн бодит үнэ цэнийг үнэлгээний загваруудыг хамарсан янз бүрийн үнэлгээний арга техникүүдийг ашиглан тодорхойлно. Боломжтой бол идэвхтэй зах зээл дээрээс эдгээр загваруудад ашиглах мэдээллүүдийг авч үнэлэх ба ийм боломжгүй тохиолдолд бусад мэдээлэл ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно. Идэвхтэй зах зээлийн болон бусад мэдээллүүд нь санхүүгийн байдлын тайланд тусгагдах санхүүгийн хөрөнгөнүүдийн бодит үнэ цэнийг тайлагнахад нөлөөлнө. Үнэлгээний загварууд нь боломжтой тохиолдолд ижил төрлийн хэрэглүүр дэх тухайн үеийн зах зээл дээрх ажиглагдаж байгаа мэдээллээс авсан үнээр тестлэгдэж баталгаажна.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэний бууралтыг авч үздэг.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Дансны авлага

Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Бусад авлага

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэний бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна.

Үүнд:

- (а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;

- (б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;
- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;
- (г) Тээврийн хэрэгсэл: Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;
- (е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд;
- (ж) Бусад үндсэн хөрөнгө: Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжид үндэслэн сонгоно; сонгосон аргыг тайлант үе бүрт тогтвортой мөрдөнө.

Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг (түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд) ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Биет бус хөрөнгийн хорогдол

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжид үндэслэн шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга эсхүл бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргуудаас аль нэгийг нь сонгон хэрэглэнэ.

Сонгосон хорогдуулалтын арга нь аж ахуйн нэгжийн хөрөнгөөс хүртэх эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлж чадахгүй байвал аж ахуйн нэгж нь шулуун шугамын аргыг хэрэглэнэ. Тодорхой ашиглалтын хугацаагүй биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдлын дүнг санхүүгийн тайланд тодруулна.

Өр төлбөр

Өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

Богино хугацаат өр төлбөр

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ. Богино хугацаат өр төлбөрийг төлөгдөх дүнгээр нь бүртгэж санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан харуулна. Үүнд:

- *Дансны өглөг*

Үүнд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

- *Цалингийн өглөг*

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна.

- *Татварын өр*

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна. НӨАТ-аас 50 хувиар чөлөөлөгддөг.

- *Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг*

Цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдлийг тооцон энэ хэсэгт тусгана.

- *Богино хугацаат зээл*

Нэг хүртэлх жилийн хугацаатай авсан зээл хамаарна.

- *Хүүний өглөг*

Богино болон урт хугацаат зээл, өрийн үнэт цаастай холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүний төлбөрийн дүнг энд тусгана.

- *Ногдол ашгийн өглөг*

Тухайн аж ахуйн нэгжийн удирдах эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-д төлөхөөр зарласан ногдол ашгийг энэ дансанд бүртгэнэ. Зөвхөн мөнгөн хэлбэрийн ногдол ашгийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг богино хугацаат өр гэж үзнэ.

- *Урьдчилж орсон орлого*

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж "Урьдчилж орсон орлого" дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэнэ.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилна.
Үүнд:

- *Урт хугацаат зээл*: Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.
- *Нөөц (өр төлбөр)*: Аж ахуйн нэгжийн баталгаат засварын өр, нөхөн сэргээлт болон бусад өр төлбөртэй холбоотойгоор байгуулсан нөөцийн урт хугацааны дүн хамаарна.
- *Хойшлогдсон татварын өр*: Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 Орлогын албан татвар – ын дагуу тооцож бүртгэлд тусгана.
- *Бусад урт хугацаат өр төлбөр*: Урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг энэ хэсэгт толилуулна.

Өмч

Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч *өмчийг* хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд өмчийг төрийн болон хувийн өмч гэж ангилж толилуулна.

Борлуулалтын орлого

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн буюу гадагш үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого зэрэг байнгын, тогтмол үйл ажиллагаанаас олсон орлогыг борлуулалтын хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр нь орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана.

- ✓ Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах

Борлуулалтын өртөг

Аж ахуйн нэгжийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээс хамаарч борлуулалтын өртөгт худалдааны чиглэлийн аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан барааны өртөг, үйлдвэрлэл болон үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан бүтээгдэхүүний өртөг хамаарна. Борлуулалтын өртгийг борлуулалтын орлоготой нь уялдуулж санхүүгийн тайланд тодруулна.

Нийт ашиг

Борлуулалтын орлогоос борлуулалтын өртгийг хасч нийт ашгийг тодорхойлно.

Ерөнхий ба удирдлагын зардал

Ерөнхий ба удирдлагын зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны болон хөгжүүлэлтийн зардал болон бусад гэж тодруулна.

Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал (орлого) нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого)-аас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан ААНОАТ-ын нийт дүн орно.

Татварын дараах ашиг (алдагдал)

Татварын дараах ашиг (алдагдал)-ийг татвар төлөхийн өмнөх ашгаас орлогын татварын зардлыг хасаж тодорхойлно.

Татвар

- ✓ Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- ✓ Хувь хүний орлогын албан татвар
- ✓ Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар зэрэг татваруудаар татварын байгууллагатай тооцоо үүсгэдэг.

ГУРАВ. “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1) Мөнгөн хөрөнгө

Балансын өдрөөрх мөнгөн хөрөнгө дараах байдлаар тайлагнагдсан. Үүнд:

Балансын өдрөөрх мөнгөн хөрөнгө дараах байдлаар тайлагнагдсан. Үнд.							
Үзүүлэлт	Валют төрөл	1/1/2025		12/31/2025		Өөрчлөгдсөн дүн	
		Гадаад валют аар	Төгрөгөөр	Гадаад валют аар	Төгрөгөөр	Гадаад валют аар	Төгрөгөөр
Касс дахь бэлэн мөнгө							
Бэлэн мөнгө	MNT	0.00	971,153.27	0.00	3,353,741.75	0.00	(2,382,588.48)
Дүн			971,153.27	0.00	3,353,741.75	0.00	2,382,588.48
Банкны харилцах дахь мөнгө							
ХХБ 405025812 (төгрөг)	MNT	0.00	349,698,654.74	0.00	602,213,975.26	0.00	252,515,320.52
ХХБ 463009182 EURO	EUR	47.14	168,147.44	47.14	198,565.79	0.00	28,418.35
Хаан банк, 5031304858	USD	77.58	265,359.29	76.20	271,028.92	1.38	5,669.63
Дүн			350,132,161.47		602,681,569.97	0.00	252,549,408.50
Нийт дүн			351,103,314.74		606,035,311.72	0.00	254,931,996.98

Харилцах болон бусад хөрөнгийн нэгдүгээр гарын үсгийг гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч О.Ганчимэг нар зурдаг

Бид 2025 оны 01 дүгээр сарын 05-ний өдөр бэлэн мөнгийг тоолж тооцоог бодоход ямар нэгэн зөрүү гараагүй болно.

Бид аудитын горимын дагуу худалдаа хөгжлийн банкинд явуулахад ам долларын данс 1.12 ам доллароор илүү, еврогийн данс 8.83 еврогоор дутуу бүртгэсэн байна.

2) Авлага

Балансын өдрөөрх авлага дараах байдлаар тайлагнагдсан. Үүнд:

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Дансны авлага	108,200,650.00	67,653,650.00	(40,547,000.00)	(0.37)
НӨАТ-ын авлага	2,523,761.92	27,269,747.62	24,745,985.70	9.81
Хойшлогдсон НӨАТ авлага	0.00	109,090.91	109,090.91	1.00
Бусад авлага	354,283,000.00	406,389,845.56	52,106,845.56	0.15
Дансны авлагын дүн	465,007,411.92	501,422,334.09	36,414,922.17	0.08

Нийт авлага тайлант жилд 36,414.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын горимын дагуу тулган баталгаажуулалтыг хийхэд нийт 2 байгууллагын 366,336.6 мянган төгрөг энэ нь нийт авлагын 73.05%-тай тэнцэж байна.

Татвар, НДШ-ийн авлага

Үзүүлэлт	31/12/2024	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
НӨАТ авлага	2,523,761.92	27,269,747.62	24,745,985.70	0.91
ДҮН	2,523,761.92	27,269,747.62	24,745,985.70	9.81

Татварын авлага тайлант жилд 24,745.9 мянган төгрөгөөр өссөн байна.

3) Урьдчилж гарсан зардал

Балансын өдрөөрх урьдчилж гарсан зардал дараах байдлаар тайлагнагдсан. Үүнд:

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Урьдчилж гарсан зардал	1,453,979.75	8,365,969.28	6,911,989.53	4.75
ДҮН	1,453,979.75	8,365,969.28	6,911,989.53	4.75

Урьдчилж гарсан зардал өмнөх жилээс 6,911.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэхүү урьдчилж төлсөн зардал нь шатахуун компанид төлсөн төлбөр, ажилсадтай хийх дараа тооцооны үлдэгдэл болно.

4) Бараа материал

Балансын өдрөөрх бараа материал дараах байдлаар тайлагнагдсан. Үүнд:

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Түүхий эд материал-50 тонн №3	84,267.25	41,961.57	(42,305.68)	(0.50)
Түүхий эд материал-50 тонн №4	38,602.19	32,586.52	(6,015.67)	(0.16)
Түүхий эд материал- 50 тонн №5	542,627.50	33,721.39	(508,906.11)	(0.94)
Түүхий эд материал- 50 тонн №6	1,022,934.08	35,084.74	(987,849.34)	(0.97)
Түүхий эд материал- 50 тонн №7	1,288,266.00	722,865.59	(565,400.41)	(0.44)
Түүхий эд материал- 50 тонн №8	627,839.71	31,044.57	(596,795.14)	(0.95)
Түүхий эд материал- 50 тонн газар доорх сав БАРУУН	797,237.43	526,389.32	(270,848.11)	(0.34)
Түүхий эд материал- 50 тонн газар доорх сав ДУНДАХ	779,939.66	58,125.30	(721,814.36)	(0.93)
Түүхий эд материал- 10 тонн босоо №1	317,195.56	89,679.74	(227,515.82)	(0.72)
Түүхий эд материал- 10 тонн босоо №2	571,288.10	510,200.01	(61,088.09)	(0.11)
Түүхий эд материал- Поошиг	243,546.96	205,593.17	(37,953.79)	(0.16)
Бэлэн бүтээгдэхүүн- 50 тонн үйлдвэр гадна сав	243,546.96	205,593.17	(37,953.79)	(0.16)
Түүхий эд материал- Поошиг	428,642.70	2,310,867.28	1,882,224.58	4.39
Бэлэн бүтээгдэхүүн- 50 тонн сав №1	486,996.39	752,843.97	265,847.58	0.55
Бэлэн бүтээгдэхүүн- 50 тн сав №2	275,812.11	775,151.17	499,339.06	1.81
Бэлэн бүтээгдэхүүн- 50 тонн үйлдвэр гадна сав	264,405.94	484,174.63	219,768.69	0.83
ДҮН	8,013,148.54	6,815,882.14	(2,707,272.35)	(0.34)

Бараа материал данс өмнөх тайлант жилээс 2,707.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материал дансны 67.46%-ийг түүхий эд материал, 32.54%-ийг бэлэн бүтээгдэхүүн эзлэж байна.

Бид 2026 оны 01 дүгээр сарын 5 нд бараа материалд түүвэр тооллого хийж тооцоог бодоход ямар нэгэн зөрүү гараагүй болно.

5) Үндсэн хөрөнгө, элэгдэл

Балансын өдрөөрх байгууллагын үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл дараах байдлаар тайлагнагдсан.

Үзүүлэлт	Хөрөнгө	12/31/2024	Нэмэгдсэн	Хасагдсан	12/31/2025
Барилга, байгууламж	Хөрөнгө	299,101,188.00	0.00	0.00	299,101,188.00
	Хуримтлагдсан элэгдэл	(35,902,743.20)	(8,975,685.80)	0.00	(44,878,429.00)
Тавилга, эд хогшил	Хөрөнгө	17,630,399.10	3,482,227.27	0.00	21,112,626.37
	Хуримтлагдсан элэгдэл	(10,390,988.18)	(1,715,103.78)	0.00	(12,106,091.96)
Машин, тоног төхөөрөмж	Хөрөнгө	749,975,899.96	21,726,025.20	0.00	771,701,925.16
	Хуримтлагдсан элэгдэл	(230,053,026.86)	(62,781,785.13)	0.00	(292,834,811.99)
Тээврийн хэрэгсэл	Хөрөнгө	678,650,000.00	479,781,818.18	150,000,000.00	908,431,818.18
	Хуримтлагдсан элэгдэл	(133,443,633.78)	(76,308,194.38)	(22,419,928.44)	(187,331,899.72)
Бусад үндсэн хөрөнгө	Хөрөнгө	17,038,118.18	0.00	0.00	17,038,118.18
	Хуримтлагдсан элэгдэл	(16,245,725.06)	(741,055.46)	0.00	(16,986,780.52)
Компьютер	Хөрөнгө	11,922,406.36	0.00	0.00	11,922,406.36
	Хуримтлагдсан элэгдэл	(8,862,661.35)	(2,265,022.29)	0.00	0.00
НИЙТ ҮНДСЭН ХӨРӨНГӨ	Хөрөнгө	1,674,318,011.60	504,990,070.65	150,000,000.00	2,029,308,082.25
	Хуримтлагдсан элэгдэл	(434,898,778.43)	(152,786,846.84)	(22,419,928.44)	(565,265,696.83)
НИЙТ ХӨРӨНГӨ		1,239,419,233.17	352,203,223.81	127,580,071.56	1,464,042,385.42

Тайлант жилд үндсэн хөрөнгө 504,990.0 мянган төгрөгөөр өссөн.

Үүнд:

- ✓ Тавилга эд хогшил – 3,482.2 мянган төгрөгөөр
- ✓ Машин тоног төхөөрөмж – 21,726.0 мянган төгрөгөөр
- ✓ Тээврийн хэрэгсэл – 479,781.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Тайлан жилд үндсэн хөрөнгө 150,000 иянгаар төгрөгөөр буурсан

Үүнд:

- ✓ Тээврийн хэрэгсэл -150,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант жилд нийт 152,786.8 мянган төгрөгийн элэгдлийг байгуулсан.

Бид аудитын горимын дагуу үндсэн хөрөнгийг 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр нийт 52 нэр төрлийн 995,520.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгөнд түүвэр тооллого хийж тооцоог бодоход ямар нэгэн зөрүү гараагүй болно. Энэ нь нийт үндсэн хөрөнгийн 67.99%-ийг эзлэж байна.

6) Биет Бус хөрөнгө

Балансын өдрөөрх байгууллагын биет бус хөрөнгө дараах байдлаар тайлагнагдсан.

Үзүүлэлт	Хөрөнгө	1/1/2025	Нэмэгдсэн	Хасагдсан	12/31/2025
Газар эзэмших эрх	Хөрөнгө	869,916,700.00	0.00	0.00	869,916,700.00
	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0	0.00	0.00
НИЙТ БИЕТ БУС ХӨРӨНГӨ	Хөрөнгө	869,916,700.00	0.00	0.00	869,916,700.00
	Хуримтлагдсан элэгдэл	0.00			0.00
НИЙТ ХӨРӨНГӨ		869,916,700.00	0.00	0.00	869,916,700.00

Биет бус хөрөнгөнд үйлдвэрийн барилгын газар эзэмших эрхийг бүртгэсэн байна.

7) Урт хугацаат хөрөнгө оруулалт

Балансын өдрөөрх байгууллагын урт хугацаат хөрөнгө оруулалт дараах байдлаар тайлагнагдсан.

Үзүүлэлт	12/31/2024	Нэмэгдсэн	Хасагдсан	12/31/2025
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,282,879,519.00	0.00	0.00	2,282,879,519.00
НИЙТ ХӨРӨНГӨ	2,282,879,519.00	0.00	0.00	2,282,879,519.00

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 2,282,879.5 мянган төгрөгийн хөрөнгө нь Шарын гол ХК-нд оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэсэн.

8) Нийт өр төлбөр

Балансын өдрөөрх байгууллагын нийт өр төлбөр дараах байдлаар тайлагнагдсан.

Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00	0.00	0.00
Богино хугацаат өр төлбөр	203,079,240.05	134,444,538.44	(68,634,701.61)	(0.34)
ДҮН	203,079,240.05	134,444,538.44	(68,634,701.61)	(0.34)

Тайлант жилд нийт өр төлбөрийн 100%-ийг богино хугацаат өр төлбөр эзлэж байгаа бөгөөд нийт өр төлбөр 68,634.7 мянган төгрөгөөр буурсан.

Богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	2/31/2024	12/31/2025	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Дансны өглөг Доллар	68,409,200.00	71,136,200.00	2,727,000.00	0.04
Орлогын татварын өглөг	44,298,736.41	54,885,913.89	10,587,177.48	0.00
Цалингийн өглөг	24,000.06	34,999.99	10,999.93	0.31
Бусад татварын өглөг	45,496.08	0.00	(45,496.08)	0.00
Бусад богино хугацаат өглөг	84,723,226.00	1,200,000.00	(83,523,226.00)	(0.99)
ХХОАТ-ын өглөг	5,578,581.50	7,187,424.56	1,608,843.06	0.22
ДҮН	203,079,240.05	134,444,538.44	(68,634,701.61)	(0.34)

Богино хугацаат өр төлбөрийн 52.91%-ийг дансны өглөг, 40.82%-ийг орлогын татварын өглөг, 0.03%-ийг цалингийн өглөг, 0.89%-ийг бусад богино хугацаат өр төлбөр, 5.35%-ийг ХХОАТ-ын өглөг тус тус эзлэж байна.

Бид дансны өглөгийг аудитын горимын дагуу тулган баталгаажуулалтыг хийхэд нийт 2 байгууллагын 72,336.2 мянган төгрөгийн баталгаажуулалт хийгдсэн. Энэ нь нийт өр төлбөрийн 53.90%-тай тэнцэж байна.

9) Эзэмшигчдийн өмч ба бусад хэсэг

Эзэмшигчдийн өмч болон эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Тайлант оны эцсийн үлдэгдэл
----------	---------------------------	-----------	-----------	-----------------------------

Эзэмшигчийн өмч	5,211,895,400.00	0.00	0.00	5,211,895,400.00
Нэмж төлөгдсөн капитал	4,592,503,138.14	0.00	0.00	4,592,503,138.14
Халаасны хувьцаа	(54,281,480.00)	0.00	0.00	(54,281,480.00)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,108,461,115.93	0.00	0.00	1,108,461,115.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	363,636.35	0.00	363,636.35
Хуримтлагдсан ашиг	(5,843,864,107.00)	589,955,859.79	0.00	(5,253,908,247.21)
ДҮН	5,014,714,067.07	590,319,496.14	0.00	5,605,033,563.21

Тайлант жилд 589,955.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

10) Нийт орлого

Балансын өдрөөрх байгууллагын орлого дараах байдлаар тайлагнагдсан.

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025	Эзлэх хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого			
Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	7,561,517,202.15	1,512,393,381.77	99.46
Борлуулалтын хөнгөлөлт	0.00	0.00	0.00
Дүн	7,561,517,202.15	1,512,393,381.77	99.46
Үндсэн бус үйл ажиллагааны орлого			
Хүүний орлого	53,851.94	8,220,567.51	0.54
Бусад орлого	2,026,660.06	160.03	0.00
Дүн	2,080,512.00	8,220,727.54	0.54
Нийт орлого	7,563,597,714.15	1,520,614,109.31	100.00

Тус компани нь тайлант жилд нийт 1,520,614.1 мянган төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Нийт орлогын 99.46%-ийг үндсэн үйл ажиллагаас 0.54%-ийг үндсэн бус үйл ажиллагаанаас олсон байна.

11) Нийт зардал

Тайлант жилд зардлыг дараах байдлаар хуримтлуулан бүртгэсэн.

Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025	Эзлэх хувь
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,460,069,187.20	553,134,423.54	59.43
Ерөнхий удирдлагын зардал	1,072,496,678.24	302,568,371.99	32.51
Дүн	7,532,565,865.44	855,702,795.53	91.95
Үндсэн бус үйл ажиллагааны олз, гарз			
Ханшийн тэгшитгэлийн алдагдал /бодит/	88,255,459.64	2,688,191.78	0.29
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	53,066.49	0.00	0.00
Үйл ажиллагааны бус бусад зардал	0.00	5,776,130.84	0.62
Дүн	88,308,526.13	8,464,322.62	0.91
Орлогын татварын зардал			
Орлогын татварын зардал	59,603,805.55	66,491,131.37	7.14
Нийт зардал	7,620,874,391.57	930,658,249.52	100.00

Тайлант жилд нийт 930,658.2 мянган төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Нийт зардлын 91.95%-ийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 0.91%-ийг үйл ажиллагааны бус зардал, 7.14%-ийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардал тус тус эзэлж байна.

12) Балансын дараах үйл явц

- Тайлант жилд ямар нэгэн үйл явц байхгүй.


13) Тус компаний 2025 оны санхүүгийн тайлангийн шинжилгээ

Тус компанийн санхүүгийн тайлангийн шинжилгээг хийхэд дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	Томъёо	Тооцоололт	Дүгнэлт
1	Нөхөлтийн коэффициент	<u>Эргэлтийн хөрөнгө</u> <u>Богино хугацаат өр</u>	4.07	Нөхөлтийн коэф-ийн зохистой харьцаа 2.0 байх ёстой ба тус компанийн хувьд 4.07 байгаа нь өр төлбөрөө төлж чадах чадвар сайн байгааг харуулж байна.
2	Авлагын цуглуулах дундаж хугацаа	<u>Авлага*365</u> <u>Борлуулалт</u>	121.01	Тус компани авлагаа дунджаа 121 хоногт багтаан цуглуулж байгааг харуулж байна.
3	Бараа материалын дундаж наслалт	<u>Бараа мат. нөөц*365</u> <u>ББӨ</u>	4.50	Бараа материалын эргэц 5 хоног байна. Энэ нь 5 хоног тутамд нэг удаа буюу жилд дунджаар 72 удаа бараа материалаа татан авдаг гэсэн үг юм.
4	Өрийн эргэц	<u>Дансны өглөг*365</u> <u>ББӨ</u>	46.94	Энэ нь эргэлтийн өр төлбөрөө 47 хоногт багтаан төлдөгийг харуулж байна.
5	Ажлын капитал	Эргэлтийн хөрөнгө- БХӨТ	988,194,958.79	Ажлын капитал буюу өрөө төлөөд үлдэх хөрөнгийг харуулж байна.
6	Гадны капитал	БХӨТ+УХӨТ	134,444,538.44	Гадны эх үүсвэр буюу зээлийн капитал 134.4 мянган төгрөг байна.
7	Байнгын капитал	УХӨТ+Өөрийн хөрөнгө	5,739,478,101.65	Байнгын капитал 5.7 тэрбум төгрөг байна.
8	Мөнгөний эргэлт	<u>Борлуулалт</u> <u>Ажлын капитал</u>	1.53	Мөнгөний эргэлт(1.53) байна.
9	Өрийн харьцаа	<u>Нийт өр төлбөр</u> <u>Нийт хөрөнгө</u>	0.02	Нийт хөрөнгийг санхүүжүүлсэнийг харуулж байна.
10	Өр ба өмчийн харьцаа	<u>Нийт өр төлбөр</u> <u>Эзэмшигчийн өмч</u>	0.02	Өр өмчийн харьцааг харуулж байна. Зохистой харьцаа 40:60 юм.
11	Ашигт ажиллагааны түвшин	<u>Цэвэр ашиг</u> <u>Борлуулалт</u>	0.39	1 төгрөгийн борлуулалт тутмаас 0.39 мөнгөний алдагдал гарч байгааг илэрхийлнэ.
12	Хөрөнгийн өгөөж	<u>Цэвэр ашиг</u> <u>Нийт хөрөнгө</u>	0.10	1 төгрөгийн хөрөнгө тутмаас 0.10 мөнгөний алдагдалтай байна.
13	Хөрөнгийн ачаалал	<u>Борлуулалт</u> <u>Нийт хөрөнгө</u>	0.26	Хөрөнгийн ачааллыг харуулж байгаа үзүүлэлт
14	Үндсэн хөрөнгө эзэмшигчдийн өмчийн харьцаа	<u>Үндсэн хөрөнгө</u> <u>Эзэмшигчдийн өмч</u>	0.26	Үндсэн хөрөнгийн 26%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.


Аудитын тайлан бичсэн:

Аудитор



Ц.Аянцэцэг


Аудиторын туслах



Э.Мөнгөннавч

Аудитын тайланд дотоод хяналт хийсэн:

Чанарын хяналтын аудитор



Б.Сансармаа

“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК
2026-02-12